



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
АЛБАН ДААЛГАВАР

2023 оны 08 сарын 04 өдөр

Дугаар 07

Хэрлэн сум

Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилтийн
бэлтгэл хангах тухай

Мал аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах ажлын хүрээнд Монгол улсын Ерөнхий сайдын 2023 оны “Хөдөө аж ахуйн салбарын 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг эрчимжүүлэх тухай” 03 тоот албан даалгавар, Засгийн газрын 2023 оны 279 дугаар тогтоол гарсантай холбогдуулан Хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэлийг байгалийн болзошгүй гамшиг, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах ажлыг орон нутгийн төр, захиргааны байгууллага, малчид, иргэд, аж ахуйн нэгжийн түвшинд сайтар ханганд биелүүлэх ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх, түүнд тавих хяналтыг сайжруулах зорилгоор сум, багийн Засаг дарга, малчид иргэдэд ДААЛГАХ НЬ:

Нэг. Сумын Засаг дарга нарт:

1.1.2023-2024 оны Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах, нарийвчилсан төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавьж, хадлан тэжээл бэлтгэлийн мэдээг 2023 оны 8 дугаар сарын 23-аас эхлэн 7 хоног бүрийн лхагва гарагт аймгийн ХХААГазарт ирүүлэх.

1.2.Монгол Улсын Засгийн Газрын 2023 оны 7 дугаар сарын 19-ны өдрийн 279 дугаар тогтоолын дагуу аймгийн аюулгүйн нөөцөд 150 тн өвс, 50 тн тэжээл, сумдын аюулгүйн нөөцөд тус бүр 60 тн өвс, 40 тн тэжээл бэлтгэж 10 дугаар сарын 01-ны дотор хадгалах цэгт байршуулсан байх. (аймаг, сумдын өвс, тэжээлийн нөөц болон малчдын бэлтгэх өвс, тэжээлийн хуваарийг 1 дүгээр хавсралтаар батлав).

1.3.Хадлан бэлтгэх боломжгүй сумдын аюулгүй нөөцийн өвсийг хадлангийн нөөц талбай бүхий сумдын удирдлагатай харилцан тохиролцож хадлангийн талбай ашиглах гэрээ хэлцлийг хийх ажлыг зохион байгуулах.

1.4. Мал сүрэгт намрын үзлэг ангилалт, заазлалт, ээмэгжүүлэлт бүртгэлжүүлэлтийн ажлыг мал үржүүлэг технологийн ажил үйлчилгээний нэгжтэй хамтран зохион байгуулах.

1.5. Хээлтэгч, хээлтүүлэгч малын тохироонд судалгаа хийж, тохироогоор дутагдаж буй хээлтүүлэгчийг нөхөн бойжуулах, худалдан авах, тохирооноос давсан хээлтэгчийг биотехнологийн дэвшилтэй арга ашиглан зохиомлоор хээлтүүлэх ажлыг орон нутагт зохион байгуулах.

1.6. Улсын тусгай хэрэгцээний аймаг дундын отрын бүс нутаг, Хилийн зурvas газар, Улсын тусгай хамгаалалттай газарт отроор өвөлжиж, хаваржих малчин өрх, малын тооны судалгааг урьдчилан гаргах, холбогдох төрийн байгууллагаас зөвшөөрөл авч малын гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд бүрэн хамрагдсан малыг отроор өвөлжүүлж хаваржуулах ажлыг зохион байгуулах.

1.7. Сумын хэмжээнд орон нутгийн тусгай хэрэгцээний отрын нөөц бэлчээрийн хил заагийг тодорхойлж, өөрийн аймаг, сумын малыг отроор өвөлжүүлж, хаваржуулах ажлыг зохион байгуулах.

1.8. Отор нүүдлээр орж ирж буй малын шилжилт хөдөлгөөнд тавих хяналтыг сайжруулж, сэжигтэй мал, амьтныг нэвтрүүлэхгүй байх бүх талын арга хэмжээ авч ажиллах.

1.9. Бэлчээрийн ургамалд хөнөөл учруулж буй хортон мэрэгч, шавжтай тэмцэх ажлыг технологит хугацаанд нь чанартай гүйцэтгүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж үр дүнг хүлээн авах, тайлагнах.

1.10. Улсын болон орон нутгийн төсөв, гадаадын төсөл, хөтөлбөрүүдийн санхүүжилтээр гаргаж байгаа инженерийн хийцтэй худаг, уст цэгийн гүйцэтгэлд хяналт тавих, 10 дугаар сард баатар хүлээн авч малчдад эзэмшүүлэх.

1.11. Малчид, иргэд өөрийн хөрөнгө оруулалтаар бэлчээрт гар худаг болон инженерийн хийцтэй худаг гаргасан, сэргээн засварласан бол тэдгээрийг бүртгэлд авч ашиглалтанд хяналт тавьж ажиллах.

1.12. Малын тэжээл үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллаж, сумын аюулгүйн нөөцийг бүрдүүлэхээс гадна малчдад малын тэжээл худалдан борлуулах ажлын уялдааг сайжруулж ажиллах.

1.13. Үр тарианы сүрэл, тэжээлийн ургамлын иш, навч болон таана, хөмүүл, халгай, лууль зэрэг ургамлуудыг даршлах, гар тэжээл бэлтгэх арга, технологийг малчдад зааж сурган бэлтгүүлэх ажлыг зохион байгуулах.

1.14.Ургац хураалтад ажиллах хүн, хүч, техник, үтрэм агуулах, элеватор, зоорийн засвар үйлчилгээ, ариутгалыг холбогдох заавар, журмын дагуу хэрэгжүүлж, шатах тослох материалын нөөцийг бүрдүүлж, бэлэн байдлыг хангах.

1.15.Ургацын урьдчилсан балансыг таримлын төрөл тус бүрээр нарийвчлан гаргах, хураах арга технологийг боловсруулах, ургац хураалтын ажлыг шуурхай зохион байгуулах, ургацын салбар штабыг байгуулж ажиллах.

1.16.Тариалан эрхлэгч аж ахуйн нэгж, иргэн бүр дотоодын ургацаасаа боловсруулж бэлтгэсэн уриншиндаа хүрэлцэхүйц хэмжээний үрийн буудайн нөөц бүрдүүлэх.

1.17.Тариалан бүхий сумд аж ахуйн нэгжүүдтэй уялдаа холбоотой ажиллаж, ургац хураалтын явцад тогтмол хяналт тавьж, шаардлагатай арга хэмжээг богино хугацаанд шуурхай шийдвэрлүүлж ажиллах.

1.18.Сумын бэлчээрийн даацад судалгаа хийж, даацаас илүү гарсан малыг эдийн засгийн эргэлтэд оруулах, төв суурингийн хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах.

1.19.Төвлөрсөн хот, суурин газрын хүн амын өвөл, хаврын улирлын махны нөөцийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах.

1.20.Малын гоц халдварт, халдварт, паразиттах өвчинөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх арга хэмжээг технологит хугацаанд нь чанартай зохион байгуулж, мал эмнэлгийн дуудлага, үйлчилгээний бэлэн байдлыг бүрдүүлж, шуурхай удирдлагаар хангах.

1.21.Бог малын хээлтүүлэгчийг хээлтүүлэгт оруулахаас өмнө нэг бүрчлэн эрүүл мэндийн үзлэгт оруулж, эрүүлийг баталгаажуулах ажлыг зохион байгуулах.

1.22.Малчин өрх бүрийн худаг, уст цэг, өвөлжөө, хашаа, хорооны хүрэлцээ хангамжийн тооцоог сум, баг, малчин өрх бүрээр гаргах, малын хашаа хороог засварлах, цаг агаар хүндэрсэн үед хэрэглэх тоног хэрэгсэл, дулаан хувцас, хоол хүнс, түлээ, нүүрс, өтөг бууц зэрэг өрхийн өвөлжилтийн бэлтгэлийг бүрэн хангуулах ажлыг зохион байгуулах.

1.23.Мал сүрэгт үзлэг ангилалт хийх, ээмэгжүүлэн бүртгэлжүүлэх, өвс тэжээлийн аюулгүйн нөөцийн өвс бүрдүүлэх, тэжээлийн агуулах, саравч барих зэрэг ХАА-н холбогдолтой ажил үйлчилгээг малын тоо толгойн албан татварын хөрөнгөөр санхүүжүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллах.

1.24.Албан даалгаврын биелэлт болон сумын мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл хангасан нэгдсэн дүнг загвар хүснэгтийн дагуу гаргаж 10 дугаар сарын 01-ны дотор аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газарт ирүүлэх.

Хоёр. Малчид, иргэдэд :

2.1.Отор нүүдлийг цаг алдалгүй хийх, малдаа тарга хүч бүрэн авахуулах, ангилалт заазлалтыг хийж дундаас доош тарга хүчтэй малд шаардагдах нэмэгдэл тэжээлийг нөөцлөх, бэлчээрийн даацаас хэтэрсэн малыг эдийн засгийн эргэлтэнд оруулах ажлыг зохион байгуулах.

2.2.Зуншлага болон цаг агаарын нөхцөл байдал, малын тарга хүчтэй уялдуулан бог малын хээлтүүлэгчийг нийлүүлэгт оруулах хугацааг тогтоох, төлөг, борлон (1 наст мал)-ыг хээлтүүлэгт оруулалгүй өнжөөх.

2.3.Мал эмнэлгийн гэрчилгээ, дүгнэлтгүй малын шилжилт хөдөлгөөн хийхийг хориглох

2.4.Өвөлжөө, хаваржааны хашаа, хороог засварлаж дулаалах, хөрзөнг ховхлон ариутгал халдвартгуйжүүлэлт хийлгэх, өтөг бууц, өвс тэжээлийг хүрэлцэхүйц хэмжээгээр нөөцлөх.

2.5.Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд малаа бүрэн хамруулах, малдаа үзлэг ангилалтад хамруулж, ээмэгжүүлж бүртгэлжүүлэх ажлыг хийлгэх.

2.6.Өрхийн өвөлжилтийн бэлтгэлийг сайтар хангаж, дулаан хувцас, түлээ түлш, хоол хүнсээ хүрэлцэхүйц хэмжээгээр нөөцлөх.

2.7.Орон нутгийнхаа онцлог, боломжид тулгуурлан хөмүүл, халгай, сүрэл, лай, халтар хомоол, хүнсний ногооны иш, навч зэргээр гар тэжээл бэлтгэх.

2.8.Намрын ургац хураалтын ажил дуустал мал сүргээ байнгын хариулга, маллагаатай байлгаж, тарианд оруулахгүй байх талаар арга хэмжээ авч ажиллах.

2.9.Малчид иргэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамрагдахдаа эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 4,2-т зааснаар эрүүл мэндийн албан даатгалд хамрагдах

Гурав: Хүнс, Хөдөө аж ахуйн газарт:

3.1.Энэхүү албан даалгаврыг аймгийн нийт ард иргэд, малчдад хэвлэл мэдээллийн бүхий л хэрэгслээр дамжуулан сурталчлах ажлыг зохион байгуулах.

3.2.Хөдөө аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл хангах тухай “Албан даалгавар”-ыг сумдад хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавьж, хадлан тэжээл бэлтгэлийн мэдээг 2023 оны 8 дугаар сарын 23-аас эхлэн 7 хоног бүрийн “Лхагва” гаригт сумдаас авч нэгтгэн холбогдох байгууллага, албан тушаалтныг мэдээллээр хангаж ажиллах.

3.3. Албан даалгаврын хэрэгжилт болон Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 7 дугаар сарын 19-ны өдрийн 279 дугаар тогтоолын дагуу аймгийн аюулгүйн нөөцөд 150 тн өвс, 50 тн тэжээл, сумдын аюулгүйн нөөцөд 1080 тн өвс, 720 тн тэжээл бэлтгэсэн дүн болон, аймгийн Хөдөө аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл хангасан нэгдсэн тайланг “Мал өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах, шалгах, дүгнэх заавар”-ын дагуу гаргаж 2023 оны 10 дугаар сарын 15-ны дотор Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст танилцуулж, ХХААХҮЯамны Мал аж ахуйн хөгжлийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлэх.

Дөрөв: Мал эмнэлгийн газарт:

4.1. Мал сүрэгт намрын угаалга, туулгалт, вакцинжуулалтын ажлыг технологит хугацаанд нь чанартай зохион байгуулах.

4.2. Мал сургийн хамуу, хурд, ширх, гуур зэрэг эктопаразитаас хамгаалах арга хэмжээг 10 дугаар сарын 01-ны дотор бүрэн хэрэгжүүлж, өвөлжөө хаваржаанд паразитын устгал, ариутгал хийх арга хэмжээг зохион байгуулах.

4.3. Бог малын хээлтүүлэгчийг хээлтүүлэгт оруулахаас өмнө нэг бүрчлэн эрүүл мэндийн үзлэгт оруулж, эрүүлийг баталгаажуулах.

Тав: Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст:

5.1. Өвөл, хаврын ган зудны болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, хохирол багатай даван туулах зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 7 дугаар сарын 19-ны өдрийн 279 дугаар тогтоолын дагуу аймгийн аюулгүйн нөөцөд 150 тн өвс, 50 тн тэжээл бэлтгэж, татан авч нөөцлөх.

5.2. Зам, давааг өвөл, хаврын улиралд байнгын нээлттэй байлгах зорилгоор хүн хүч, техникийн бэлтгэл, бэлэн байдлыг хангуулж, техник тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлэх арга хэмжээг “Харгуй” ТӨҮГазартай хамтран хэрэгжүүлж ажиллах.

5.3. Албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж, хадлан тэжээл бэлтгэх боломжгүй сумдыг хадлан тэжээл бэлтгэх боломжоор хангах асуудлыг шийдвэрлэж, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 279 дугаар тогтоолын хэрэгжилт болон Аймгийн Хөдөө аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангаж, хяналт тавьж ажиллах.

Зургаа: Аймгийн онцгой комиссын гишүүдэд:

6.1. Мал аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах ажлын хүрээнд Монгол улсын Ерөнхий сайдын 2023 оны “Хөдөө аж ахуйн салбарын 2023-

2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг эрчимжүүлэх тухай” 03 тоот албан даалгавар, Засгийн газрын 2023 оны 279 дугаар тогтоол гарсантай холбогдуулан Хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэлийг байгалийн болзошгүй гамшиг, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах ажлыг орон нутгийн төр, захиргааны байгууллага, малчид, иргэд, аж ахуйн нэгжийн түвшинд сайтар ханган биелүүлэх ажлыг зохион байгуулахад аймгийн онцгой комиссын гишүүд хамтран ажиллахыг (аймгийн онцгой комиссын гишүүдийн хариуцан сумдын аюулгүйн нөөц болон малчдын бэлтгэх өвс, тэжээл бэлтгүүлэх хуваарийг 2 дугаар хавсралтаар батлав) үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023
оны 07 дугаар сарын 04-ны
дугаар албан даалгаврын нэгдүгээр хавсралт

АЙМАГ, СУМДЫН АЮУЛГҮЙН НӨӨЦ БОЛОН
МАЛЧДЫН БЭЛТГЭХ ӨВС, ТЭЖЭЭЛ-

№	Сумын нэр	Засгийн газрын 2023 оны 279 дүгээр тогтоолын дагуу аймаг, сумдын аюулгүйн нөөцдөд бэлтгэх		Малчин өрхийн хэрэгцээнд зориулан бэлтгэх		
		Өвс /тн/	Тэжээл /тн/	Өвс /тн/	Тэжээл /тн/	Гар тэжээл /тн/
1	Галшар	60	40	1000	10	5
2	Баянхутаг	60	40	1000	10	5
3	Баянмөнх	60	40	1000	10	5
4	Дархан	60	40	1000	10	5
5	Дэлгэрхаан	60	40	2000	10	5
6	Жаргалтхаан	60	40	2000	10	5
7	Цэнхэрмандал	60	40	2000	10	5
8	Өмнөдэлгэр	60	40	20000	10	5
9	Батширээт	60	40	10000	10	5
10	Биндэр	60	40	13000	10	5
11	Баян-Адарга	60	40	13000	10	5
12	Дадал	60	40	30000	10	5
13	Норовлин	60	40	10000	10	5
14	Батноров	60	40	8000	10	5
15	Баян-Овоо	60	40	3500	10	5
16	Мөрөн	60	40	3500	10	5
17	Хэрлэн	60	40	8000	10	5
18	Бор-Өндөр	60	40	1000	10	5
Сумдын дүн		1080	720	130000	180	90
Аймгийн нөөц		150	50	-	-	-
Нийт дүн		1230	770	130000	180	90

Аймгийн Засаг даргын 2023
оны 07 дугаар сарын 04-ны
дугаар албан даалгаврын хоёрдугаар хавсралт

**АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН ГИШҮҮДИЙН ХАРИУЦАН СУМДЫН
АЮУЛГҮЙН НӨӨЦ БОЛОН МАЛЧДЫН БЭЛТГЭХ ӨВС, ТЭЖЭЭЛ БЭЛТГҮҮЛЭХ
ХУВААРЬ**

№	Аймгийн онцгой комиссын гишүүдийн хариуцах сумд	Сумын нэр	Засгийн газрын 2029 оны 279 дүгээр тогоолын дагуу аймаг, сумдын аюулгүйн нөөцөд бэлтгэх		Малчин өрхийн хэрэгцээнд зориулан бэлтгэх		
			Өвс /тн/ /тн/	Тэжэ эл /тн/ /тн/	Өвс /тн/ /тн/	Тэжэ эл /тн/ /тн/	Гар тэжээл /тн/ /тн/
1	Г.Мөнх-Эрдэнэ	Галшар	60	40	1000	10	5
2	Ч.Баярцолм он	Баянхутаг	60	40	1000	10	5
3	О.Баярлхагва	Баянмөнх	60	40	1000	10	5
4	Л.Батсайхан	Дархан	60	40	1000	10	5
5	Ж.Гантулга	Дэлгэрхаан	60	40	2000	10	5
6	Ж.Эрдэнэба т	Жаргалтхаан	60	40	2000	10	5
7	Э.Мөнх-Эрдэнэ	Цэнхэрман дал	60	40	2000	10	5
8	Б.Дарханбаатар	Өмнөдэлгээр	60	40	2000 0	10	5
9	Н.Хүрэлзээ	Батширээт	60	40	1000 0	10	5
10	Х.Доржханд	Биндэр	60	40	1300 0	10	5
11	Н.Анхбаяр	Баян-Адарга	60	40	1300 0	10	5
12	Д.Өнөрцэцэг	Дадал	60	40	3000 0	10	5
13	Б.Бат-Эрдэнэ	Норовлин	60	40	1000 0	10	5
14	М.Өлзийбат	Батноров	60	40	8000	10	5
15	Х.Уртнасан	Баян-Овоо	60	40	3500	10	5
16	С.Нямдаваа	Мөрөн	60	40	3500	10	5
17	М.Шүрэнцэц эг	Хэрлэн	60	40	8000	10	5

1 8	Д.Батхүү	Бор-Өндөр	60	40	1000	10	5
		Сумдын дүн	108 0	720	1300 00	180	90
	Л.Батсайхан	Аймгийн нөөц	150	50	-	-	-
		Нийт дүн	123 0	770	13000 0	180	90